



УУЛ УУРХАЙН ЖИШИГ СУРГУУЛЬ ГОВЬСҮМБЭР
АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

ИЛТГЭЛ

Сэдэв: Багшийн хөгжилд онлайн сургалт нэвтрүүлсэний ач холбогдол

Илтгэгч багш боловсрол судлалын магистр Б. Мэндбаяр

ЧОЙР ХОТ 2019 ОН

АГУУЛГА

- Үндэслэл
- Судалгааны ажлын зохилго
- Судалгааны ажлын зорилтууд

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Судалгааны материал арга зүй

- Судалгааны хамрах хүрээ
- Түүвэрлэлт, материал арга зүй
- Судалгаанд ашигласан үндсэн ойлголтууд
- Судалгааний мэдээлэл боловсруулалт

ХОЁРДУГААР БҮЛЭГ. Судалгааны ажлын үр дүн

- Судалгаа 1
- Судалгаа 2

Дүгнэлт

Дэвшүүлж байгаа санаа.

Ном зүй

Нэг. Үндэслэл

Шинэ зууны боловсролын нэг гол шинж бол нээлттэй сургалт, зайны сургалтын арга хэлбэр өргөжиж байгаа явдал мөн. Боловсролын тухай хуульд хөгжлийн шинэ нөхцөл байдлыг харгалзан боловсролын зорилгыг иргэдийнхээ бие даан сурч, амьдрах чадвартай болгоход нь үйлчлэх чиглэлээр шинэчлэн тодорхойлсон билээ. Боловсролын хэрэгцээг орон зай, цаг хугацаанаас төдийлэн шалтгаалахгүйгээр уян хатан, олон хувилбартай, нээлттэй, хүртээмжтэй, чанартай, үр ашигтайгаар хангах тогтолцоо бий болгох нь чухал байна.

Сургуулийн өмнөх боловсрол, бага, суурь, бүрэн дунд боловсрол, техник, технологи, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг нэмэгдүүлэх, хүүхдийн суралцах, хөгжих эрхийг тэгш боломжоор хангах, иргэдийн насан туршдаа суралцаж, мэргэжил боловсролоо дээшлүүлэх, амьдрах чадвараа хөгжүүлэхэд зайны сургалт чухал ач холбогдолтой гэдгийг иш үндэс болгож, зайны сургалтын нөөц, шинээр бий болж байгаа боломжийг тогтвортой бүтэц болгон өргөжүүлж үр өгөөжийг нь нэмэгдүүлэхийн тулд Засгийн газраас Зайны сургалтын үндэсний хөтөлбөрийг гаргаж байна. Зайны сургалтын үндэсний хөтөлбөр нь Бүх нийтийн боловсролын үйл ажиллагааны хүрээг баталсан Дакарийн тунхаглалыг хэрэгжүүлэх талаар Монгол Улсын Засгийн газраас явуулах үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг байх болно¹.

Хоёр. Судалгааны ажлын зорилго

Энэхүү судалгааны зорилго нь мэргэжлийн боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж, 3 жил, 1 жил, 1,5 жилийн ангид ажил хийн суралцаж байгаа оюутануудад насан туршдаа суралцах бололцоо олгоход нь дэмжлэг үзүүлэх зайны сургалтын тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлэхэд оршиж байна.

Судалгааны ажлын зорилтууд

- Зайны сургалтын хүртээмжтэй, чанартай, үр ашигтай мэдээлэл, техникийн орчин бий болгох.

¹ “ЗАЙНЫ СУРГАЛТЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР” УЛААНБААТАР ХОТ 2002 тал 1

- Зайны сургалтын оновчтой хэлбэрийг сонгон агуулга, арга зүйг боловсруулж хэрэгжүүлэх.
- Тухайн мэргэжлээр ажиллаж байгаа оюутануудын суралцах хөтөлбөр боловсруулах.


НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Судалгааны материал арга зүй

Нэг. Судалгааны хамрах хүрээ

- Хэнтий аймаг МСҮТөв, Бор-Өндөр МСҮТөв Говьсүмбэр ПТК.

Хоёр. Түүвэрлэлт, материал арга зүй

- Чадамж нь Мэдлэг, чадвар, хандагын цогц юм²



Гурав. Судалгаанд ашигласан үндсэн ойлголтууд

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1 Зайны сургалтын бодлогын зохицуулалт, менежментийн тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.1. Зайны сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлого, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, түүнтэй нийцүүлсэн шийдвэр гаргаж, дэд хөтөлбөр хэрэгжүүлэх;

² “Чадамжид суурилсан сургалтын гарын авлага” Улаанбаатар 2013 он тал 25

3.1.2. Зайны сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг холбогдох яамтай хамтран боловсруулж, хэрэгжүүлэх;

3.1.3. Зайны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шалгуур, үзүүлэлтийг мөргөжлийн байгууллагатай хамтран боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх;

3.1.4. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, хандивлагч орны тусламж, хувийн хөрөнгө оруулалт, хандив, дотоодын эх үүсвэр, нөөц зохих тодотгол хийж, цаашдын бодлого, чиглэлийг тодорхойлох;

3.1.5. Зайны сургалтын мэдээллийн сан бий болгон ашиглах;

3.1.6. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үе шатны явц, үр дүнг харгалзан хөтөлбөрт зохих тодотгол хийж, цаашдын бодлого, чиглэлийг тодорхойлох;

3.1.7. Зайны сургалтын үндэсний хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжүүлэхэд төрийн захираганы бүх шатны байгууллага, олон улсын мөргөжлийн төрөлжсөн байгууллага, хандивлагч орон, төрийн бус байгууллага, сонирхлын бүлэг, иргэдийн өргөн түншлэлийг бий болгож оролцоог нэмэгдүүлэх.

3.2. Зайны сургалтын үйлчилгээ, үйл ажиллагааны механизм бүрдүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.1. Зайны сургалтыг стратегийн удирдлага, төлөвлөлтөөр хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хянах, үнэлэх, Засгийн газарт тайлагнах үүргийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам хэрэгжүүлэх. Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайдаар ахлуулсан төрийн болон мөргөжлийн, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллага, иргэд, хандивлагчдын төлөөллөөс бүрдсэн зөвлөх үүрэгтэй зайны сургалтын зөвлөлийг ажиллуулах;

3.2.2. Үндэсний түвшинд зайны сургалтын хэрэгцээ, хүртээмжийн судалгаа хийх, мөргөжил, арга зүйн зөвлөлтөө, удирдлагаар хангах, үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулах, боловсон хүчин бэлтгэх, мөргөжил дээшлүүлэх сургалтын агуулга, арга зүйг боловсруулах чиг үүргийг мөргөжил, арга зүйн байгууллага, төслийн багийн оролцоотойгоор хэрэгжүүлэх;

3.2.3. Үндэсний түвшинд зайны сургалтын мэдээллийг нэгтгэж сан бүрдүүлэх, мөргөжлийн болон арга зүйн зөвлөлтөө өгөх, үйлчилгээ үзүүлэх, үр дүнг тайлагнах

үүргийг Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төв хариуцан гүйцэтгэх; Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төвийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяа Албан бус боловсролын төвийг өргөтгөх замаар байгуулж, үйл ажиллагааг нь төсвөөс санхүүжүүлэх;

3.2.5. Нутаг дэвсгэрийн түвшинд зайны сургалтын үйлчилгээг бүх шатны боловсролын байгууллага хариуцан зохион байгуулах.

3.3. Зайны сургалтын мэргэжилтэн бэлтгэх, хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.3.1. Зайны сургалтын чиглэлээр ажиллаж байгаа боловсон хүчний өнөөгийн байдалд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах;

3.3.2. Зайны сургалтын мэргэжилтэн бэлтгэх олон хувилбартай сургалтын төлөвлөгөө, агуулга, стандарт боловсруулан хэрэгжүүлэх;

3.3.3. Мэргэжлийн байгууллага, төслийн багийн нөөц бололцоонд тулгуурлан мэргэжилтэн бэлтгэх, тэдний мэргэшлийг дээшлүүлэх, давтан бэлтгэх түр болон богино хугацааны сургалтыг зохион байгуулах;

3.3.4. Зайны сургалтын чиглэлээр зохиогдож байгаа олон улсын хурал, сургалт, семинарт зайны сургалтын мэргэжилтэн, арга зүйчдийг оролцуулах;

3.3.5. Зайны сургалтын чиглэлээр олон улсын, үндэсний түвшний сургалт, семинар зохион байгуулах;

3.3.6. Өндөр хөгжилтэй оронд зайны сургалтын үндэсний боловсон хүчин бэлтгэх бодлогыг дэмжин хэрэгжүүлэх.

3.4. Зайны сургалтын хүртээмжтэй, чанартай, үр ашигтай мэдээлэл, техникийн орчин бий болгох зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.4.1. Монгол Улсад бий болсон зайны сургалтын мэдээлэл, техникийн орчин, түүний ашиглалтад үнэлгээ өгч, дүгнэлт гаргах;

3.4.2. Радио, телевизийн нэвтрүүлгийн программд сургалтын цаг гаргаж, зардлыг төрөөс санхүүжүүлэх, цаашид боловсролын бие даасан сувагтай болох асуудлыг судалж шийдвэрлэх;

3.4.3. Төв, орон нутгийн мэргэжлийн байгууллагын зайны сургалтын хэвлэмэл болон аудио, видео материал бэлтгэх, теле хичээл явуулах, бэб сайт нээх техникийн чадавхийг үе шаттайгаар сайжруулах;

3.3.4. Бүх түвшний боловсролын байгууллагыг үндэсний мэдээлэл харилцааны тогтолцоо, интернетийн сүлжээнд холбогдох техникийн боломжийг өргөжүүлэх;

3.3.5. Зайны сургалтын хэрэглэгдэхүүнийг сонирхогч хүнд хүргэх, ашиглах боломж бүхий тогтолцоо бүрдүүлэх;

3.3.6. Зайны сургалтын мэдээлэл, техникийн орчин бүрдүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, бэлтгэхэд хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллага, сонирхлын бүлгүүдийн дэмжлэг, оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.4 Зайны сургалтын оновчтой хэлбэрийг сонгон агуулга, арга зүйг боловсруулж, хэрэгжүүлэх зорилтын хүрээний үйл ажиллагаа:

3.4.1. Мэргэжлийн байгууллагатай хамтран ерөнхий боловсролын сургуулийн сурагч, бүх шатны суралцагч, иргэдэд зориулсан Англи хэлний зайны сургалтын агуулга, арга зүйг боловсруулан хэрэгжүүлэх;

3.4.2. Багш болон боловсролын удирдах ажилтныг давтан бэлтгэх, мэргэшлийг дээшлүүлэх зайны сургалтын агуулга, арга зүйг боловсруулж хэрэгжүүлэх үйл ажиллагааг хүртээмжтэй, тасралтгүй, тогтвортой болгох;

3.4.3. Дээд боловсролын сургалтад зайны сургалтын арга, технологийг нэвтрүүлэх, зайны сургалтын оновчтой хэлбэрийг хөгжүүлэх;

3.4.4. Хувийн хэвшлийн эрэлт, хэрэгцээнд тулгуурласан зайны сургалтын агуулга, арга зүйг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулж, хэрэгжүүлэх замаар мэргэжилтэн, ажилчдын мэдлэг, чадавхийг бэхжүүлэх;

3.4.5. Албан бус, тасралтгүй боловсролын хүрээнд эрүүл мэнд, экологи, эрх зүй, эдийн засаг, гэр бүл зэрэг бүх нийтийн боловсролын ерөнхий түвшинг дээшлүүлэх зайны сургалтын агуулга, арга зүйг боловсруулан хэрэгжүүлэх;

3.4.6. Компьютер, интернат, интернет ашиглан явуулах сургалтын агуулга, арга хэлбэрийг тогтоох, программ хангамжийн нэгдсэн тогтолцоо, сүлжээ бий болгох.

Дөрөв. Судалгааний мэдээлэл боловсруулалт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам

4.1. Хөтөлбөрийн зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ дараахь зарчим, арга замыг ашиглана:

4.1.1. Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах;

4.1.2. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, хандивлагчдыг зайны сургалтыг хөгжүүлэхэд оролцох боломжоор хангах, хөрөнгө, хүчийг зохистой хуваарилах, түншлэлийг бэхжүүлэх;

4.1.3. Зайны сургалтын хүрсэн түвшинг хадгалж олон хувилбартай, уян хатан, нээлттэй, онцлог байдлаа харгалзах;

4.1.4. Зайны сургалтын агуулга, стандартын түвшинг тухайн боловсролын стандарт түвшингээс бууруулахгүй байх;

4.1.5. Зайны сургалтыг зохион байгуулахдаа иргэдийн хэрэгцээ, сонирхлыг харгалзан, чөлөөт байдлыг хангаж, сурах чадварыг нь хөгжүүлэхэд чиглүүлэх;

4.1.6. Албан болон албан бус боловсролын нэгдлийг хангах, хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх;


4.1.7. Зайны сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулах олон эх үүсвэрийг бий болгох;

4.1.8. Зайны сургалтад мэдээлэл, харилцааны дэвшилтэт технологи ашиглах.


ХОЁРДУГААР БҮЛЭГ. Судалгааны ажлын үр дүн

Судалгаа


Судалгаанд хамрагдсан багшийн нас




Судалгаанд хамрагдсан багшийн хүйс



Та мэргэжлийн боловсролын салбарт хэд дэхь жилдээ ажиллаж байгаа вэ?




Та мэргэжлийн боловсролын салбарт ямар төрлийн хичээл ордог вэ?




Судалгаа 2


Зайн сургалтыг мэргэжлийн боловсролын салбарт ашиглах нь тохиромжтой юу?



Зайны сургалтын бодлогын зохицуулалт, менежментийн тогтолцоог бий болгох шаардлага байгаа юу?




Зайны сургалтын хэлбэрийг сонгоход та оюутнуудтай ажиллахдаа ямар арга ашигладаг вэ?




Зайны сургалтын онлайн хэлбэрээр явуулах ямар арга нь илүү үр дүнтэй вэ?

Chart Title




Сурч байгаа мэргэжлээрээ мэргэжлийн ажил хийж байгаа оюутанд зайны сургалтын ямар хэлбэр ашиглах хэрэгтэй вэ?



Танай сургууль зайны сургалтыг сургалтандаа ашигладаг уу?

Chart Title



ТУРШИЛТ 1

- Багшийн зайны сургалтын дэвтэр гаргаж налайх 415-р ангийн ХММАУЗТ За ангийн хичээл сургалтанд ашиглаж байн.
- Судалгаанаас харахад багш оюутан 2 тусдаа нэг дэвтэртэй байх нь зөв байна.



ТУРШИЛТ2

- Налайх 353-р ангийн ХММАУЗ тех 3а ангийн 19 оюутан
- Гидравлик системийн засвар оношлогоо хичээлээр 2019,02,04 өдөр дараах даалгавар өгөв.
- **Даалгавар 1**
- Машины гидро насос задлах видео хичээл үзэх.
- **Даалгавар 2**
- Үзсэн хичээлээ ашиглан гидро насос задлах дадлага хийх.
- **Даалгавар 3**
- Дадлага хийж байгаа явцийг бичлэг хийж баталгаажуулах.
- **Даалгавар 4**
- Баталгаажуулсан бичлэгээ багшийн mmendeebad7903@gmail.com хаягруу 2019,03,04 нөөс өмнө явуулах.

ТУРШИЛТ 2 АНГИ НАЛАЙХ 353-Р АНГИ ХММАУ ЗА ЦАХИМ ДААЛГАВАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

№1	Оюутны нэр	Mail хаяг	Өгсөн Даалгавар	Даалгавар Өгсөн он сар өдөр	Даалгавар өгөх он сар өдөр	Багшид ирүүлсэн он сар өдөр
1	Асалбек	asalbek1986@gmail.com	Video хичээл судлах	2019,02,04	2019,03,4	2019.03.3
2	Цогт	Tsogt1988@gmail.com	Video хичээл судлах	2019,02,04	2019,03,4	2019,03,05
3	Баяртогтох		Video хичээл судлах	2019,02,04	2019,03,4	
4	Батдорж	Batdorj199703@gmail.com	Video хичээл судлах	2019,02,04	2019,03,4	2019.03.04
5	Алтаншагай		Video хичээл судлах	2019,02,04	2019,03,4	
6	Энхтөр		Video хичээл судлах	2019,02,04	2019,03,4	2019.03.05
7	Ганболд		Video хичээл судлах	2019,02,04	2019,03,4	

Дүгнэлт

- Мэргэжлийн боловсролын салбарт зайны сургалтын арга одоо болтол сайн нэвтрээгүй.
- Хэнтий МСҮТ, Бор –Өндөр МСҮТ Өмнөговь ПК зайны сургалтыг ашигладаггүй.
- Манай сургууль зөвхөн 3 жил, 1,5 жил, 1 жилийн ангид ашигладаг .
- Зайны сургалтын багшийн үнэлгээний дэвтэр байх шаардлагатай сургалтыг албанаас оюутны үнэлгээний дэвтэр гаргаж туршилт хийж байгаа.
- Багшийн үнэлгээний туршилтын дэвтэр гаргаж Налайх 353-р ангид ХММАУЗ тех 3а ангид цахим даалгавар өгч үнэлгээ хийж байгаа.
- Багш нараас гарсан саналаар мэргэжлээрээ ажиллаж байгаа оюутны зайны сургалтыг илүү боловсронгуй болгох гэсэн саналууд их гарсан.

ДЭВШҮҮЛЭХ САНАА

- Цахим хичээл илүү ихээр зайны сургалтанд ашиглах.
- Зайнаас сурж байгаа оюутнууд компьютерийн мэдлэгийг хамгийн түрүүнд сайжруулах.
- Мэргэжлээрээ ажиллаж байгаа оюутны зайны сургалтын хөтөлбөр гаргах.
- Зайны сургалтын багшийн болон оюутны дэвтэрт туршилт хийж сайжруулах.
- Цахим хичээлийн сантай болох багш нар
- Зайн сургалтын нэгдсэн зөвлөмж гаргах бүс болон яамнаас.

Багш бид нар юу хийж чадах вэ?

- Багш бүр цахим хичээлтэй болох 1 чадамжын хөтөлбөрийг цахим болгох
- 1 чадамжийн нэгжийг видео хичээл болгох.

Ном зүй

- <http://www.itpd.mn/index.php?r=content/view&id=856>
- “Багш бүр чиглүүлэгч” Дуламсүрэн Саранчимэг 2016 он

- “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийг чадавхжуулах нь” 2014 он
- “Сургалтын процессын удирдлага” 2015 Ч. Туул